



**“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд  
“Хүүхэд хамгааллын мэдлэг бататгах сургалт” -ын модуль боловсруулах зөвлөх  
баг шалгаруулах ажлын удирдамж**

**1. Төслийн товч танилцуулга**

Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд болон Говь-Алтай, Ховд аймгуудын ерөнхий боловсролын нийт 14 сургуулийг түшиглэн 2023 оны 01 дүгээр сараас 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна.

**2. Төслийн зорилго, зорилтууд**

Төслийн зорилго нь орон нутагт сургуулийн багш ажилтнууд, эцэг эх/асран хамгаалагчид, сурагчид болон хамтарсан багуудыг хамруулан сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг хөгжүүлснээр хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны загвар бий болгох явдал юм.

***Төслийн зорилтууд***

- 1) Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын механизмыг бүрдүүлэн, бэхжүүлэх
- 2) Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авахад сургууль, орон нутаг, үндэсний түвшний сайн зохицуулалт, хяналтын тогтолцоо бүхий Хүүхэд хамгааллын механизмуудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- 3) Хүүхэд хамгааллын асуудлыг давах туулах хүүхдүүдийн чадвар нэмэгдэнэ. Хүүхдүүд өөрсдийн хамгаалагдах эрхийн талаар мэдлэгтэй болж, аливаа асуудалтай тулгарсан үед өөрийгөө халамжлах ба үе тэнгийнхэндээ сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ур чадварт суралцахад чиглэж байна.

**Үндэслэл, хэрэгцээ шаардлага**

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан “Сургуулийн орчинд хүүхэд хамгааллыг сайжруулах нь” (2023-2025) төслийн хүрээнд боловсролын орчин дахь хүүхэд хамгааллыг бэхжүүлэх, боловсролын орчин дахь ёс зүйн хэм хэмжээг сахиулахад анхааран ажиллаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах, хүртээмжтэй сургалтын орчныг бий болгох, суралцагчдын сайн сайхан байдлыг дэмжихэд багш, сурган хүмүүжүүлэгч чухал үүрэгтэй байдаг.

Боловсролын орчинд хүүхэд хамгаалал болон суралцагч, эцэг эх асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдийн ёс зүйн нарийн төвөгтэй асуудлууд улам бүр нэмэгдэж байна. Хүүхэд хамгааллын сургалтыг сурган хүмүүжүүлэгчдэд сэргээн сануулж, дахин бэлтгэх шаардлага үүсэж байна.

Энэхүү сургалтын модуль нь хүүхдийн дээд эрх ашиг, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьсан оновчтой шийдвэр гаргах, тэгш хамруулах зарчмыг хүндэтгэх, улмаар боловсролын орчны чанарыг сайжруулахын тулд багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулахад чиглэх болно.

Хүүхэд хамгааллын олон улсын стандарт, тухайлбал Боловсролын орчинд эрхэд суурилсан хандлага, практик бий болгох үндэс суурийг бүрдүүлж буй НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай конвенц, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилттэй Монгол улсын боловсролын тогтолцоо нийцэж буй байдлыг ахиулах зорилготой сургалтын модуль юм. Хүүхдийн Эрхийн тухай конвенцын ерөнхий санал зөвлөмжийн нэгдүгээр зарчмыг онцгойлон анхаарч, хүүхдийн хөгжлийн төлөө хүүхэд нэг бүрийн эрх, сайн сайхан байдлыг дэмжих, аюулгүй таатай орчныг бүтээхэд чиглэнэ.

## **1. Зөвлөх ажлын зорилго**

1. Хичээлийн жилийн эхэнд Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх, ёс зүйн хэм хэмжээгээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх 16 цагийн багц агуулга бүхий сургалтын модуль дагалдах хэрэглэгдэхүүнийг боловсруулах;
2. Багш нарын давтан сургалтаар дамжуулан Хүүхэд хамгааллын сургалт зохион байгуулах сургагч багшид зориулсан сургагч багшийн гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулах;
3. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх, ёс зүйн хэм хэмжээгээ баримтлахад дэмжлэг үзүүлэх 16 цагийн багц агуулгаар сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах
4. Боловсруулсан сургалтын модульд үндэслэн төслийн зорилтот ерөнхий боловсролын сургуулиудын хамгааллын багийн гишүүдэд цахим болон танхимын сургалтыг зохион байгуулах

## **2. Сургалтын модулийн агуулга**

"Хүүхэд хамгааллын мэдлэг бататгах сургалт" (2 өдөр/16 цаг)

### **Бүлэг 1 (6 цаг)**

- Хүүхдийн эрхийн тухай ойлголт: НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц, Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн зохицуулалтын тойм
- Хүчирхийллийн шинж тэмдэг: Бие махбод, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл, үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэл
- Мэдээлэх механизм: Хүчирхийллийн талаар мэдээлэх журам, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад сурган хүмүүжүүлэгчийн ёс зүйн хариуцлага, нууцлал

- Кейс судалгаа: Сурган хүмүүжүүлэгчдийн ажлын болон амьдралын орчинд тохиолддог бодит жишээнүүдийг хэрэглэн, тэд өөрсдийн мэдлэгээ ашиглан асуудлыг шийдвэрлэх, зүй зохистой арга хэмжээ авахад нь туслах

## Бүлэг 2 (10 цаг)

- Боловсролын орчин дахь ёс зүйн асуудлууд, сурагчдын эрх, нэр төрийг хүндэтгэсэн, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтгүй сургалтын орчныг бий болгох
- Ёс зүйн хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд нь тус болохуйц практик мэдлэгийг багш, сурган хүмүүжүүлэгчдэд олгох, сурагчдын орчныг ёс зүйтэй, хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх
- Хүйсийн эрх тэгш байдлыг дэмжих: Эрэгтэй, эмэгтэй сурагчдад тэгш боломжийг олгох арга барилууд
- Багш-сурагчийн харилцааны хил хязгаар: Мэргэжлийн хил хязгаарыг баримтлах, зохисгүй харилцаанаас зайлсхийх
- Эцэг эхтэй эерэг харилцаа тогтоох: Эцэг эхтэй баримтлах харилцаанд нээлттэй, хүндэтгэлтэй, дэмжлэг үзүүлэх арга барилыг эрхэмлэх, гэр бүл, эцэг эхтэй харилцахдаа мэргэжлийн ёс зүй, сэтгэл хөдлөл, бусдыг ойлгох чадамжийг зөв зохистой хослуулах

## 3. Сургалтын модулийн бүтэц

| Бүтэц                | Агуулга                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                   |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Модулийн зорилго     | Хичээлийн жилийн эхэнд Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх, ёс зүйн хэм хэмжээгээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх 16 цагийн багц агуулга бүхий сургалтын модуль дагалдах хэрэглэгдэхүүнийг боловсруулах |                                                                                                                                                                   |
| Хугацаа              | 5 сарын 19 – 9 сарын 1 хүртэл                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                   |
| Агуулгын бүрэлдэхүүн | Суралцагчдад өгөх мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                       | Танилцуулах мэдээллийн агуулга                                                                                                                                    |
|                      | Ашиглах материал                                                                                                                                                                                                                                                                                 | <ul style="list-style-type: none"> <li>• Танилцуулга/үзүүлэн</li> <li>• Видео</li> <li>• Дасгал даалгавар</li> <li>• Тараах материал, ашиглах хэрэгсэл</li> </ul> |
|                      | Арга зүй                                                                                                                                                                                                                                                                                         | Сургалт хэрхэн явагдах аргачлал                                                                                                                                   |
|                      |                                                                                                                                                                                                                                                                                                  | Ашиглах сургалтын аргууд                                                                                                                                          |
|                      |                                                                                                                                                                                                                                                                                                  | Электрон агуулга, зайны сургалтын хэлбэр буюу хосолсон сургалтын арга зүйд тохируулж болохуйц байх                                                                |
|                      |                                                                                                                                                                                                                                                                                                  | Бодит кейсүүд болон бүтээлч тоглоом, дасгалууд г.м                                                                                                                |
| Үнэлгээ дүгнэлт      | Сургалтад оролцогчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                   |

|                                                 |                                                                                    |
|-------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
| Хавсралт                                        | Модуль сургалтын агуулгаар бэлтгэсэн холбогдох мэдээлэл, танилцуулах материал      |
| Сургагч багшид зориулсан сургалтын гарын авлага | Сургалтыг зохион байгуулах сургагч багшид зориулсан алхамчилсан арга зүйтэй байна. |

#### 4. Багийн ажил үүргийн хуваарь

Ажил гүйцэтгэх баг нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн ажилтнуудын техникийн туслалцааг авч, байнга зөвшилцөж ажиллана.

#### 5. Төслийн багт хүлээлгэн өгөх материал

- Зөвлөх баг нь "Хүүхэд хамгааллын мэдлэг бататгах сургалт" -ын модулийг эцэслэн цаасаар болон цахим хэлбэрээр
- Зорилтот сургуулиудын хамгааллын багийн гишүүдэд зохион байгуулсан сургалтын тайлан
- Модуль боловсруулах явцын болон эцсийн тайлан (Монгол, Англи хэл дээр)

#### 6. Ажлын хүрээ, хугацаа

Зөвлөх баг нь дараах ажлын хүрээг баримтлан ажиллана.

| ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД                                                                                                            | ХУГАЦАА |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|
| Бэлтгэл үе шат                                                                                                               |         |
| Зөвлөх ажлын нөхцөлийн талаар тохиролцох<br>(Ажлын гэрээ, гүйцэтгэх ажил, хуваарь гэх мэт)                                   |         |
| Төслийн чиглэл, үзэл санаатай танилцах                                                                                       |         |
| Гэрээнд гарын үсэг зурах                                                                                                     |         |
| Модуль боловсруулах шат                                                                                                      |         |
| Сургалтын модулийн дизайн, бүлэг тус бүрийн агуулгыг боловсруулах                                                            |         |
| Сургалтын модулийн дизайн, агуулгыг төслийн багаас санал авч хэлэлцүүлэх                                                     |         |
| Холбогдох санал хүсэлтүүдийг тусган засан сайжруулах                                                                         |         |
| Сайжруулсан хувилбарыг төслийн баг болон бусад зөвлөх баг, холбогдох байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэх, дахин боловсруулах |         |
| Сургалтын модулийг эцэслэн боловсруулж дуусгах                                                                               |         |
| Боловсруулсан материалуудыг ХИС-д цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх                                               |         |
| Сургагч багшийн гарын авлагыг эцэслэх                                                                                        |         |
| Сургагч багшид зориулсан сургалтын гарын авлагыг ХИС-д цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх                          |         |

|                                                                                                             |  |
|-------------------------------------------------------------------------------------------------------------|--|
| Сургагч багш бэлтгэх болон зорилтот сургуулиудын хүүхэд хамгааллын багийн гишүүдэд сургалт зохион байгуулах |  |
| Сургалт зохион байгуулах                                                                                    |  |
| Сургалтын тайлан боловсруулж ирүүлэх                                                                        |  |
| Модуль боловсруулах явцын болон эцсийн тайлан боловсруулах                                                  |  |
| Модуль боловсруулах явцын тайлан (Монгол, Англи хэл дээр)                                                   |  |
| Модуль боловсруулсан эцсийн тайлан (Монгол, Англи хэл дээр)                                                 |  |

## 7. Зөвлөх багт тавигдах ерөнхий шаардлага

- Баг нь 3-5 гишүүнтэй байх
- Багийн гишүүд боловсрол, нийгмийн ухаан зэрэг чиглэлээр магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байх
- Сургалтын хөтөлбөр, агуулга, гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр 5 буюу түүнээс дээш жил үр бүтээлтэй ажилласан байх
- Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байсан бол давуу талтай
- Компьютерын оффис програмууд дээр чөлөөтэй ажиллах чадвартай байх
- Багаар ажиллах чадвартай байх
- Англи, Монгол хэл дээр тайлан боловсруулах чадвартай байх

### Бүрдүүлэх материал:

- Сургалтын модуль боловсруулах ажлыг гүйцэтгэх сонирхлыг илэрхийлсэн захидал, үүнд багийн давуу талуудыг харуулсан байх.
- Сургалтын модуль боловсруулах ажлын төлөвлөгөө (хугацаа, аргазүй, аргачлал, зохион байгуулалт зэрэг).
- Зөвлөх багийн ахлагч болон гишүүдийн анкет, ажлын туршлагыг харуулсан мэдээлэл.
- Судалгааны зөвлөмж боловсруулах ажлын үнийн санал, төсөв

Сонирхол бүхий зөвлөх баг бүрдүүлэх материалыг битүүмжлэн, 2025 оны 5-р сарын 16-ны 15.00 цагаас өмнө дараах хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг:** Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар, Хүүхдийг Ивээх Сан.

Цахим хаяг: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)